



МОНГОЛ ГАЗРЫН ТОС БОЛОВСРУУЛАХ  
ҮЙЛДВЭР ТӨХХК

900, Бодь цамхаг, 1-р хороо, Чингэлтэй дүүрэг  
Улаанбаатар 14200, Монгол улс  
Утас: +976 70100389  
И-мэйл: [info@mongolrefinery.mn](mailto:info@mongolrefinery.mn)

2019.03.14 № 69/19

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_

МУИС, ХЭРЭГЛЭЭНИЙ  
ШИНЖЛЭХ УХААН,  
ИНЖЕНЕРЧЛЭЛИЙН  
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ  
Н. БААТАРБИЛЭГ ТАНАА

### Хүсэлт гаргах тухай

Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан “Газрын тос боловсруулах үйлдвэр барих” төслийг манай компани хэрэгжүүлж байна.

Тус боловсруулах үйлдвэрийн нарийвчилсан ТЭЗҮ-ийг БНЭУ-ын Engineers India Limited компани боловсруулж дууссан. Уг ТЭЗҮ-ийн тооцолсны дагуу үйлдвэрт 560 гаруй инженер техникийн ажилтан шаардлагатай байгаагаас 200 гаруй нь газрын тосны боловсруулалтын инженер мэргэжилтэй байхаар байна. Манай компани нь үйлдвэрийг барьж байгуулах, ашиглалтанд оруулахад шаардлагатай инженер-техникийн ажилчдыг бэлтгэх мөн ирээдүйд уг үйлдвэрт ажиллах нарийн мэргэжлийн боловсон хүчнийг гадаадын их, дээд сургуульд сургах, мэргэшүүлэх талаар арга хэмжээ авч байна.

Үүний дагуу БНЭУ-аас Монгол Улсад суугаа Онц бөгөөд бүрэн эрхт Элчин сайд ноён М. П. Сингхтэй уулзаж, тус улсын Засгийн газрын тэтгэлгээр бакалаврын түвшинд газрын тосны боловсруулалтын чиглэлээр оюутнуудыг сургах талаар ярилцаж, 2019-2020 оны хичээлийн жилд 5 оюутанг сургах боломжийг Элчин сайд олгосон болно.

Иймд, Хэрэглээний шинжлэх ухаан, инженерчлэлийн сургуулийн 1-2 курсад суралцаж буй, англи хэлний өндөр түвшний мэдлэгтэй, Энэтхэг Улсын Засгийн газрын тэтгэлгээр сурах хүсэлтэй, улмаар тус боловсруулах үйлдвэрт үндсэн ажилтан болж ажиллах оюутнуудын жагсаалтыг холбогдох мэдээллийн (анкет) хамтаар 2019 оны 03-р сарын 20-ны дотор ирүүлж бидний ажилд гүн тусалцаа үзүүлнэ үү.

Хавсралтаар Монгол Улсад суугаа БНЭУ-ын Элчин сайдын яамнаас зарласан тэтгэлгийн мэдээллийг хавсаргав.

Хүндэтгэсэн,

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Д. АЛТАНЦЭЦЭГ